



ДУНДОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2013 оны 12 сарын 12 өдөр

Аймаг 222

Эд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 1998 оны 148 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.3, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 тоот тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахад баримтлах журмын 2 дугаар зүйлийн 2.1, 2.1.4 дахь заалтуудыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн 556'000'000 /таван зуун тавин зургаан сая/ төгрөгийн хөрөнгөөр барьсан Төрийн албан хаагчийн 12 айлын орон сууцыг хувьчилж үл болох эд хөрөнгийн жагсаалтанд оруулсугай.
2. Тус орон сууцыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу үндсэн хөрөнгийн бүртгэж, ашиглалт, засвар үйлчилгээ хийх журам гарган мөрдөж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга /О.Чулуунбат/-д даалгасугай.
3. Төрийн улс төрийн болон төрийн тусгай албыг тодорхой хугацаагаар хашихаар томилогдсон дараах албан тушаалтнуудыг уг орон нутгийн өмчийн орон сууцанд суулгаж байхаар тогтоосугай.

- Үүнд:
1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга
 2. Аймгийн Засаг дарга
 3. Аймгийн Засаг даргын орлогч
 4. Аймгийн Ерөнхий прокурор
 5. Аймгийн Ерөнхий Аудитор
 6. Цэргийн штабын дарга

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн алба П.Очирбат/-нд үүрэг болгосугай.

ДАРГА  С.БУДЖАВ